



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2007 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

**“Даатгалын нягтлан бодох бүртгэлийн
дансны заавар” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 29.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. ”Даатгалын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ ЗААВАР

НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Энэ журмыг даатгалын хураамж, нөөц сан, давхар даатгал, хохирол нөхөн олгохтой холбоотой гарсан ажил гүйлгээ, нягтлан бодох бүртгэлд тусгахад баримтална.

1.2. Энэ журам нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын агуулга хэлбэрийн хүрээнд мөрдөгдөнө.

ХОЁР. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, данс бичилт

2.1. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлийг бодит үнээр бүртгэнэ. Валютын орлого зарлагын гүйлгээг гүйлгээ гарсан өдрийн Монголбанкнаас зарласан ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлэн бүртгэнэ.

2.2. Даатгалын компанийн мөнгөн хөрөнгийг дүрмийн сангийн мөнгөн хөрөнгө, даатгалын мөнгөн хөрөнгө гэж ангилж тус тусад нь хөтөлнө.

2.3. Дүрмийн сангийн болон даатгалын мөнгөн хөрөнгийн харилцах дансны хооронд гүйлгээ хийхдээ Санхүүгийн зохицуулах хороонд заавал мэдэгдэнэ.

2.4. Харилцах дансны мөнгөн хөрөнгийг гадаад валют болон бусад хэлбэрээр байршуулах болвол мөнгөн хөрөнгийн харилцахтай нэгэн адил тус тусад нь данс нээж бүртгэл хөтөлнө.

2.5. Даатгалын хураамжийн орлогыг “даатгалын хураамжийн орлого” дансны кредитээс даатгалын мөнгөн хөрөнгө дансны дебетэд бичнэ.

2.6. Тайлангийн хугацаанд байгуулсан гэрээтэй холбоотой нөхөн олговрыг:

- урьдчилж төлсөн нөхөн олговор дт-д;
- даатгалын хураамжийн мөнгөн хөрөнгө кт-с.

2.7. Өмнөх тайлангийн хугацаанд байгуулсан гэрээтэй холбоотой нөхөн олговруудыг:

- нэхэмжилсэн хохирлын нөөц дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

2.8. Тайлангийн хугацаанд байгуулсан гэрээний хураамжийг буцаан олговол:

- буцаасан даатгалын хураамжийн орлого дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

2.9. Өмнөх тайлангийн хугацаанд байгуулсан гэрээний хураамжийн орлогыг буцаавал:

- орлогод тооцоогүй хураамжийн орлогын дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с;
- зөрүү гарвал тайлант хугацааны ашиг алдагдал дансны дт-д

тус тус бичилт хийнэ.

2.10. Давхар даатгалд шилжүүлэх хураамжийн орлого орж ирвэл:

- даатгалын мөнгөн хөрөнгийн дт-д;
- давхар даатгалын өглөгийн кт-с.

2.11. Давхар даатгагчид давхар даатгалын хураамжийн орлогыг шилжүүлвэл:

- давхар даатгалын өглөг дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

2.12. Даатгалын хураамжийн орлого орж ирэхээс өмнө давхар даатгагчид хураамжийн орлогыг урьдчилж шилжүүлвэл:

- даатгалын хураамжийн авлага дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

2.13. Давхар даатгагчид урьдчилж төлсөн хураамжийн орлого орж ирсэн нөхцөлд:

- даатгалын мөнгөн хөрөнгө дт-д;
- даатгалын хураамжийн авлага кт-с.

ГУРАВ. Хураамжийн орлогын бүртгэл, бичилт

3.1. Даатгалын хураамжийн орлогыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Сайн дурын даатгалын хэлбэрийн жагсаалт”-ын хэлбэр тус бүрээр бүртгэнэ.

3.2. Тайлангийн хугацаанд орж ирсэн хураамжийн орлогоос “Даатгалын нөөц сан бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2.7 дахь заалтын дагуу орлогод тооцсон хураамжийн орлогыг тооцож

- а/ - хураамжийн орлого дт-д;
- орлогод тооцоогүй хураамжийн орлого кт-с.
- б/ - орлогод тооцоогүй хураамжийн орлого дт-д;
- орлогод тооцсон хураамж кт-с.

3.5. Өмнөх тайлангийн хугацаанд байгуулсан гэрээтэй холбоотой хохирол нөхөлт гаргасан бол:

- нэхэмжилсэн хохирлын нөөц сангийн дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

3.6. Даатгалын хураамжийн орлого нь тусгай хуваарийн дагуу ээлж дараалалтай төлбөр хийгдэх гэрээний нөхцлөөр хохирол нөхөлт гаргавал:

- урьдчилж төлсөн хохирол нөхөн олговор дт-д;

- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

3.7. Давхар даатгагчид хураамжийн орлого шилжүүлвэл:

- даатгалын хураамжийн орлого дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

3.8. Давхар даатгагчаас урьдчилж орж ирсэн нөхөн олговрын мөнгөн хөрөнгийг:

- даатгалын мөнгөн хөрөнгө дт-д;
- давхар даатгагчийн урьдчилгаа кт-с.

3.9. Давхар даатгагчаас олгогдох нөхөн төлбөрийг урьдчилж төлвөл:

- давхар даатгалын авлага дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

3.10. Давхар даатгалын шимтгэлийн орлогыг:

- даатгалын хураамжийн орлого дт-д;
- давхар даатгалын шимтгэлийн орлого кт-с.

ДӨРӨВ. Нөөц сангийн бүртгэл, дансны бичилт

4.1. Даатгалын компани нөөц санг Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Нөөц санг бүрдүүлэх хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д заасан ангилалаар байгуулж нягтлан бодох бүртгэлд тусгана.

4.2. Нөөцийн сангуудыг тусад нь байгуулж бүртгэлд тусгах боловч нөөцийн сангийн мөнгөн хөрөнгийг тусад нь ангилж бүртгэхгүй.

4.3. Тайлангийн хугацаанд орлогод тооцсон хураамжийн орлогоос нөөц сангуудыг байгуулахдаа:

- орлогод тооцсон хураамжийн орлого дт;
- нэхэмжилсэн хохирлын нөөц кт-с;
- учирч болзошгүй хохирлын нөөц кт-с;
- даатгалын орлого кт-с.

4.4. Давхар даатгалд шилжүүлж байгаа даатгалын гэрээний хариуцлагаас өөрт үлдсэн хэсэгт нөөц сан байгуулвал:

- даатгалын хураамжийн орлого дт-д;
- учирч болзошгүй хохирлын нөөц данс кт-с.

4.5. Нөөц сангуудаас хохирол нөхөлт хийхдээ:

а/ тайлангийн хугацаанд байгуулсан гэрээний хохирол нөхөлтийг нөөцийн санд хаах болвол:

- орлогод тооцсон хураамж эсвэл учирч болзошгүй хохирлын нөөц дт-д;
- урьдчилж төлсөн хохирлын нөхөн олговор кт-с.

б/ өмнөх тайлангийн хугацаанд байгуулсан гэрээтэй холбоотой хохирлын нөхөн олговрыг:

- нэхэмжилсэн эсвэл учирч болзошгүй хохирлын нөөц дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

4.6. Учирч болзошгүй хохирлын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийвэл:

- хөрөнгө оруулалтын данс дт-д;
- даатгалын мөнгөн хөрөнгө кт-с.

4.7. Учирч болзошгүй хохирлын нөөц сангаас хийсэн хөрөнгө оруулалтын ногдох орлогыг нөөц санд бүртгэх болвол:

- даатгалын мөнгөн хөрөнгө дт-д;
- учирч болзошгүй хохирлын нөөц кт-с.

4.8. Нөөц сангаас оруулсан хөрөнгө оруулалтын алдагдлыг ашиг алдагдлын дансанд хаана.

4.9. Дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг зохих журмын дагуу байршуулснаас орсон орлогыг:

- дүрмийн сангийн мөнгөн хөрөнгө дт-д;
- хуримтлагдсан ашиг алдагдал кт-с.

ТАВ. Даатгалын бус үйл ажиллагааны бүртгэл

5.1. Даатгалын компанид гарч буй зардлуудыг даатгалын үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардал гэж ангилна.

5.2. Даатгалын бус үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 116 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар”-ыг мөрдлөг болгоно.

--ooOoo--